



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/236

Булган сум

Аймгийн хурдан морины бүсийн уралдааны
2023 оны хуваарийг тогтоох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2023 онд зохион байгуулагдах хурдан морины бүсийн уралдааны хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хурдан морины уралдааныг тогтоосон хугацаанд холбогдох хууль тогтоомж болон уралдааны дүрмийн дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд, унаач хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр явуулахыг холбогдох сумын Засаг дарга нар, “Булганхангай” морин спорт уяачдын холбоо /Ж.Бат-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

3.Хурдан морины уралдааны явцад байнгын хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар (Т.Баярбат) –т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0323010337

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын
11-ны өдрийн А/29 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ХУРДАН МОРИНЫ БҮСИЙН
УРАЛДААНЫ 2023 ОНЫ ХУВААРЬ

№	Уралдааны нэр	Зохион байгуулах газар	Уралдааны нас	Зохион байгуулах хугацаа	Зохион байгуулагч
1	“Бүрэгхангай-100” дээд насны хаврын бүсийн уралдаан	Бүрэгхангай сум	-Азарга, -Их нас, -Соёолон, -Сонгомол дээд	2023.05.01	“Бүрэгхангайн хурд” морин спорт уяачдын холбоо
2	“Баатар вангийн хурд-2023” хурдан дааганы уралдаан	Хутаг-Өндөр сум	-Даага	2023.05.03	“Хутаг-Өндөрийн хурд” морин спорт уяачдын холбоо
3	“Хишиг-Өндөр-100” хаврын бүсийн уралдаан	Хишиг-Өндөр сум	-Хязаалан, -Шүдлэн, -Даага, -Сонгомол дунд -Сонгомол доод	2023.05.05	“Бишрэлт гүний хурд” морин спорт уяачдын холбоо
4	Аймгийн алдарт уяачдын нэрэмжит “Булганхангайн хурд-2023” аймгийн бүсийн уралдаан	Булган сум	-Их нас, -Соёолон, -Сонгомол дээд	2023.05.06	Аймгийн морин спорт уяачдын холбоо
5	“Булганхангай ирээдүйн түмэн эх-2023” аймгийн бүсийн уралдаан	Булган сум	-Даага	2023.05.06	Аймгийн морин спорт уяачдын холбоо
6	“Сайханы хурд” аймгийн бүсийн уралдаан	Сайхан сум	-Хязаалан, -Шүдлэн, -Даага,	2023.05.06	“Сайхан борлог” морин спорт уяачдын холбоо
7	“Ингэттолгой-80” хаврын бүсийн уралдаан	Сэлэнгэ сум	-Хязаалан, -Шүдлэн, -Даага, -Сонгомол дунд -Сонгомол доод	2023.05.07	“Цонхлон хурд” морин спорт уяачдын холбоо
8	“Агтын хийморь-2023” аймгийн бүсийн уралдаан	Баян-Агт сум	-Хязаалан, -Шүдлэн, -Даага,	2023.05.13	“Агтын хийморь” морин спорт уяачдын холбоо

			-Сонгомол дунд, -Сонгомол доод		
9	“Булганхангайн шигшмэл хурд-2023” уралдаан	Булган сум	-Азарга, -Их нас -Сонгомол дээд	2023.07.18	Аймгийн морин спорт уяачдын холбоо